

Б. Одгэрэл\*, Ц. Атарболд\*\*

### **Монголын Хөдөө аж ахуйн их сургууль, ХБНГУ-ын Бавари муж улсын Вайнштефаны мэргэжлийн их сургуулийн хамтын ажиллагаа**

1995 онд Монгол улс болон ХБНГУ-ын Бавари мужийн хооронд байгуулсан шинжлэх ухаан, боловсролын хүрээнд хамтран ажиллах гэрээний дагуу 1996 оны V сард ХААИС-ийн 3 багш Вайнштефаны мэргэжлийн их сургуульд айлчилж тус сургуулийн үйл ажиллагаатай танилцан, профессор багш нартай монголын ХААИС-д Жимс-ногооны сургалтыг хөгжүүлэх талаар хамтран ажиллахаар тохиролцсон байна.

1996 оны VIII сард Германы профессор Ф.Френц, Х. Хельм нар Монголд зочилж ХААИС, Дарханы УГТСЭШХ, Шаамар, Мандалговь зэрэг газруудаар аялж Монгол орны байгаль цаг уурын нөхцөлтэй танилцаад буцжээ. 1997 оны II сард Ф. Френц, Х. Хельм нар Монголын ХААИС дээр "Жимс-ногооны сургалт" сэдэвтэй симпозиум зохион байгуулж, багш, эрдэм шинжилгээний ажилтан, оюутан, зарим газар тариалангийн компаниудын төлөөлөгчид, хувиараа ногоо тариалагчид зэрэг хот хөдөөгийн 100-аад хүн оролцжээ. Ийнхүү хоёр сургуулийн хамтын ажиллагааны эхлэл тавигдаж зарим төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

### **Хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй гол ажлууд**

1999 онд Германы талаас KLIWADU программ бүхий компьютер, автомат усалгааны төхөөрөмжийг ирүүлсэн ба ХААИС дээр уг төхөөрөмжийг суурилуулан усалгааны лаборатори байгуулагдан, хүлэмж баригдаж сургалт судалгаанд ашиглагдаж эхлэв.

\* ХААИС-ийн багш, магистр

\*\* ХААИС-ийн багш, магистр

Хоёр сургуулийн хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, "Жимс, хүнсний ногоо" төслийг хэрэгжүүлэхэд Германы профессор Ф. Френцийн хувь нэмэр их байлаа. Энэ хүн 2000 оноос эхлэн ХААИС дээр жил бүр 4-5 сарын хугацаагаар ажиллаж, багш, оюутнуудыг сургах, сургалт семинар зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж байна.

Хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж байгаа чухал ажлын нэг бол дуслын усалгааны аргыг манай нөхцөлд турших, үүнийг тариалан эрхлэгч нарт сурталчлах, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ юм. 2001 оноос проф. Ф. Френцийн санаачилгаар "Дуслын усалгааны групп" байгуулагдсан. Тус групп нь ХААИС-ийн харъяа Төв агропаркийн эдлэн газарт тодорхой хэмжээний талбайд дуслын усалгааны систем тавьж, германы 20 гаруй төрлийн хүнсний ногоо, герман сортын төмс тариалж, сорт судалгаа болон бусад туршилт судалгааны ажлуудыг жил бүр явуулж байна. 2000-2003 онуудад дуслын усалгаатайгаар нийт 3 магистр, 16 бакалаврын дипломын ажлын туршилт тавигдав. Оюутнуудад хүнсний ногооны маркетингийг биечлэн үзүүлэх зорилгоор тариалсан ногоогоо Хан брой, Брау хауз зэрэг зоогийн газрууд болон ТБД андууд, Меркури зэрэг худалдааны төвүүдээр борлуулж байна. Мөн хийж байгаа шинэлэг ажил бол цэцэг тариалах, цэцгийн аж ахуйн талаархи мэдлэгийг оюутнуудад олгох явдал юм. Үүнтэй холбоотойгоор жил бүр цэцгийн үрслэг бэлтгэн сургуулийнхаа цэцгийн мандал, хүлэмжийн орчинд, түүнчлэн Ханброй, Брау Хауз зэрэг зоогийн газруудын гадна цэцэг тариалдаг боллоо. Тус хамтын ажиллагааны хүрээнд сургалт семинарыг байнга зохион байгуулж ирлээ. Тухайлбал 1998-2002 онуудад Германы проф. Х. Хелм, Ф. Френц нарын оролцоотойгоор ХААИС-ийн Агробиологи, Эдийн засгийн сургуулиуд хамтран "Жимс, хүнсний ногооны маркетинг" семинарыг зохион байгуулж, тус сургуулиудын багш, оюутнуудыг өргөнөөр хамруулж байлаа. Мөн дуслын усалгааг хүмүүст сурталчлах, уг усалгааг хэрэглэн төрөл бүрийн хүнсний ногоо, төмс тариалах аргыг үйлдвэрлэгчид, төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч иргэд, оюутнуудад үзүүлэх, заах, дэлгэрүүлэх зорилгоор жил бүр

хоёроос доошгүй сургалт семинар, талбайн өдөрлөг зохион байгуулж байна.

2003 оны VII сард "Монгол дахь төмсний үрийн үйлдвэрлэл" сэдэвт семинарыг ХААИС дээр зохион байгуулав. Энэ нь цаашид уг хамтын ажиллагааны хүрээнд төмсний эрүүл үр үйлдвэрлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх зорилго агуулж байснаараа онцлог байлаа.

2001 оноос эхлэн хичээлийн шинэ жилийн нээлтээр ХААИС дээр Дуслын усалгааны группээс төрөл бүрийн хүнсний ногоо, цэцгийн үзэсгэлэн зохион байгуулж ирлээ. Хамтын ажиллагааны хүрээнд нийт 4 сая гаруй төгрөгний ном сурах бичиг Вайнштефаны Мэргэжлийн их сургуулиас буцалтгүй тусламжаар ирүүлж ХААИС-ийн номын санд хөдөө аж ахуйн чиглэлийн ном сурах бичгийн баяжуулалт хийлээ.

Хамтын ажиллагааны хүрээнд ХААИС дээр герман хэлний тусгай курсыг жил болгон зохион байгуулж ирлээ. Энэ курсад хамрагдсан багш оюутнуудаас шалгаруулан Вайнштефаны мэргэжлийн их сургуульд дадлагажуулах, мэргэжил дээшлүүлэхээр явуулж байгаагаас гадна тус сургууль дээр зохион байгуулагдаж байгаа олон улсын Бизнесийн удирдлагын магистрын сургалтад сургаж байна.

### **Хамтын ажиллагаанаас гарч буй үр дүн**

"Жимс хүнсний ногоо" төслийг хэрэгжүүлж, усалгааны лаборатори, сургалтанд зориулсан хүлэмж түүнчлэн профессор Ф. Френцийн санаачилгаар "Дуслын усалгааны групп" байгуулан үйл ажиллагаа явуулж байна.

"Жимс-хүнсний ногооны маркетинг" семинар болон бусад сургалт семинарыг үйлдвэрлэгчид, хувиараа төмс хүнсний ногооны тариалан эрхлэгч иргэд, багш, оюутнуудыг хамруулан зохион байгуулж, түүнчлэн ХБНГУ-ын хөрөнгө оруулалттай зарим байгууллагуудтай түншийн харилцаа тогтоов.

Герман хэлний тусгай сургалтыг 2000 оноос эхлэн зохион байгуулж ирсэн. үүнд: Нийт 80 багш, оюутан хамрагдав.

ХААИС-ийн багш, оюутнуудаас жил бүр Вайнштефаны мэргэжлийн их сургуульд үйлдвэрлэлийн дадлага хийж,

магистрантурт сурч, мэргэжил дээшлүүлж байна. Энэ чиглэлээр Германд явсан нийт 10 багш, 22 оюутан байна. ХААИС нь ХБНГУ-д зохион байгуулагдаж байгаа Бизнесийн удирдлагын магистрын сургалтын сүлжээнд нэгдэв. ХААИС-ийн номын санд ХБНГУ-аас хөдөө аж ахуйн чиглэлийн ном сурах бичгийн баяжуулалт хийгдэв.

Жич: 2002 оны VII сард Бавари муж улсын Засгийн газрын БСШУЯ-ны төлөөлөгчид хатагтай Ленглер, ноён Ролц нар уг хамтын ажиллагааны хүрээнд ХААИС дээр хийгдэж байгаа ажлуудтай танилцаж, үнэлгээ өгөхдөө хоёр сургуулийн хоорондын хамтын ажиллагаанд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байв.